



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/147/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
Bayankhongor@audit.gov.mn  
Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цээням  
Утас:70444470 Цахим хаяг:  
Аудитор:Д.Энхтуяа  
Утас: 99449299 Цахим хаяг: tomoo\_etuya@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4.1.Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17
4.6. Аудитлагдсан нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.ДАГВАДОРЖ ТАНАА

*2020.02.27* № *1/287*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020256

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал С.Дагвадоржтанд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-нээс 2020.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Глобал капитал аудит ХХК-ны аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Глобал капитал аудит ХХК-ны газарт 2020.02.19-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Суралцагчдын сурлагын ахиц амжилтыг дээдлэн, сурах арга барил, төлөвшил хандлагыг эрхэм болгож олон нийтийн оролцоог дэмжихэд оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах
- Чанартай, хүртээмжтэй, ахицтай боловсролын үйлчилгээг хүргэх
- Багш, сурагч солилцоо хөтөлбөр боловсруулан ажиллах
- Эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэн ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд Өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Аcolouc программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дундгэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 860162.9 мянган төгрөгөөс тооцон 17203.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17203.2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95970.5 мянган төгрөгөөр буюу 5.7 %-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 101759,1 мянган, бараа материалын дансны үлдэгдэл 5788,1 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	1,305.40	1,305.40	-
Урьдчилгаа			-
Бараа материал	81,688.60	87477,3	5,788,1
Үндсэн хөрөнгө	1881314.8	1900542.3	19227.4
Хуримтлагдсан элэгдэл	-255387.9	-376374.5	-120986.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,708,920.90</b>	<b>1,612,950,5</b>	<b>(95,570,5)</b>
Өр төлбөр	1,232.20		(1,232.20)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,707,688.80	1,612,950,5	(94,738,3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,708,921.00</b>	<b>1,612,950,5</b>	<b>(95970.5)</b>

Авлага өмнөх оноос 1305,4 мянган төгрөгөөр буурч, тайлант онд авлага байхгүй байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд төсвийн хөрөнгөөр 19227,4 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5788,1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмнөх оны өглөг 1232,2 мянган төгрөг байснаас бууруулж тайлант онд үлдэгдэлгүй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд 99570,5 мянган төгрөгөөр тайлант хугацааны үр дүнгийн өөрчлөлтөөр нэмэгдсэн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 746481,9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 746481,9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 635284,0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 111197,9 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 742186,7 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 4295,1 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв:** Төрийн сангаас нэмэлт санхүүжилтээр 16914,0 мянган төгрөг орж ирснийг сургалт, тэтгэмжийн зардалд зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорилхэрэгжүүллээ.

Аудитаар нийт 52979,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 3129,8 мянган төгрөгийн албан шаардлага, 45646,6 мянган төгрөгийн залруулга, 3620,2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардал, ажил олгогчийн нийгмийн даатгалын зардлуудыг хооронд нь гүйлгэн буруу бичилт хийсэн зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Аудитаар дараах 6750,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага, дүгнэлт хязгаарлахаар шийдвэрлэлээ. Үүнд:

1. Дотуур байрны Хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 2846,4 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Ажилтан Б.Сугарбаяр, Ц. Мөнхбат нарт 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/48 тоот тушаалаар сахилгын арга хэмжээ авч, 2019 оны 2,3,4 дүгээр улирлуудын үр дүнгийн урамшуулалд 773,8 мянган төгрөг олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 тоот тогтоолоор батлагдсан, "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" –ын 4,3 дахь заалтыг тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Багш Ж.Ганзоригийг ажлаас халагдаад Шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон 2018 оны 10 дугаар сараас 2019 оны 04 дүгээр сарын 01 хүртэлх хугацааны цалин 3129867 төгрөгийг цалингийн зардлаас төлсөн

Энэ нь Захиргааны тухай хуулийн 103.1 дэх заалтыг зөрчсөн байна.,

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4. Дотуур байр, үдийн цайны хүүхдийн ирц нярвын тайлангаас жижүүрийн багшийн бүртгэл зөрүүтэй, тооллогын комисс томилогдсон боловч тооллогын бүртгэлийг холбогдох батлагдсан маягтаар үйлдэж албажуулж гарын үсэг зураагүй, тооллогын үр дүнг хэлэлцээгүй, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдээгүйгээс 2019 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Аудитаар Хязгаарлалттай дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар цалинг санхүүгийн программаар бодох, өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж мөрдөөгүй зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

### Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	3	3	5
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	4	4	2	2	
4	Сар бүр	36	36	33	3	
5	Тухай бүр	96	96	64	32	
	Нийт	151	151	105	41	5

Нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас 41 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн байна. 5 мэдээний хугацаа болоогүй байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийн хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд

#### **1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

##### **1.1. Илрүүлэлт:**

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2.-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

##### **1.2. Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

#### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

#### **2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

##### **2.1. Илрүүлэлт:**

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай бүрэн тооцоо нийлээгүй байна

Энэ нь НББ-ын тухай хуулийн Энэ нь 19.1.4. “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

## **2.2. Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэлд өглөг авлага үндэслэлгүй нэмэгдэх, эд хөрөнгө дутагдах, шамшигдах

## **2.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж, сар бүр бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо нийлж, үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулж байх

## **2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>82,994,175.34</b>	<b>88,782,750.42</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,305,477.00	1,305,477.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,305,477.00	1,305,477.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	81,688,698.34	87,477,273.42
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,021,600.00	1,911,300.00
35110	Тусгай зориулалттай материал	1,868,400.00	1,868,400.00
35130	Эм боох материал	153,200.00	42,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	79,667,098.34	85,565,973.42
35410	Бичиг хэргийн материал	1,279,300.00	3,292,700.00
35420	Аж ахуйн материал	73,307,938.34	76,383,938.34
35440	Түлш, шатах тослох материал	00.00	21,460.08
35460	Хүнсний материал	3,457,360.00	2,846,445.00
35470	Бусад хангамжийн материал	1,622,500.00	3,021,430.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,625,926,900.62</b>	<b>1,524,167,802.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,625,926,900.62	1,524,167,802.31
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,584,212,067.72	1,482,527,302.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,552,461,640.00	1,552,461,640.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-92,977,400.61	-187,657,541.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,815,708.26	184,215,708.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-116,384,830.98	-136,658,126.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,665,640.96	94,383,640.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,184,544.84	-51,143,324.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	3,000,000.00
39217	Ном	20,815,854.93	23,925,304.93
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	41,714,832.90	41,640,500.00
39301	Програм хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-841,167.10	-915,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,426,000.00	41,426,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,708,921,075.96</b>	<b>1,612,950,552.73</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,232,215.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,232,215.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,232,215.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,232,215.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,707,688,860.96</b>	<b>1,612,950,552.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,707,688,860.96	1,612,950,552.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	364,824,419.85	364,824,419.85
51101	Өмч: - төрийн	364,824,419.85	364,824,419.85
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	625,099,124.69	530,360,816.46
51210	Өмнөх үеийн үр дүн	625,099,124.69	625,099,124.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-94,738,308.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	717,765,316.42	717,765,316.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,708,921,075.96</b>	<b>1,612,950,552.73</b>

#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>744,828,943.00</b>	<b>765,424,596.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>51,485,000.00</b>	<b>2,028,696.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	51,485,000.00	2,028,696.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,485,000.00	2,028,696.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,028,696.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	51,485,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,775,343.00</b>	<b>128,111,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	681,568,600.00	635,284,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	681,568,600.00	635,284,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,089,286.00	16,914,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,089,286.00	16,914,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	111,197,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	111,197,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	686,057.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	686,057.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>736,067,408.80</b>	<b>860,162,904.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>736,067,408.80</b>	<b>860,162,904.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	673,827,326.80	835,067,953.23
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	397,976,123.00	478,182,831.00
210101	Үндсэн цалин	397,976,123.00	473,901,743.00
210102	Нэмэгдэл	00.00	1,089,028.00
210104	Урамшуулал	00.00	3,192,060.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,006,708.00	66,742,300.00
210201	Тэтгэврийн даатгал	48,006,708.00	29,978,168.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	8,360,780.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,257,008.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,579,255.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	20,567,089.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	128,036,911.00	103,919,390.00
210301	Гэрэл, цахилгаан	5,866,384.00	5,723,085.00
210302	Түлш, халаалт	122,170,527.00	98,196,305.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,840,896.20	7,777,213.92
210401	Бичиг хэрэг	1,496,630.00	3,307,630.00

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210402	Тээвэр, шатахуун	1,073,470.00	1,259,539.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	104,697.00	310,844.00
210404	Ном, хэвлэл	84,000.00	233,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,082,099.20	2,485,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,648,790.00</b>	<b>32,295,371.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,100.00	580,366.00
210502	Хоол, хүнс	37,277,010.00	31,715,005.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	338,680.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,530,000.00</b>	<b>6,549,600.00</b>
210602	Тавилга	00.00	1,572,500.00
210604	Урсгал засвар	1,530,000.00	4,977,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>416,300.00</b>	<b>1,406,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	416,300.00	1,406,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,414,200.00</b>	<b>9,964,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,414,200.00	9,564,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,957,398.60</b>	<b>128,230,547.31</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,992,000.00	6,073,999.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,028,000.00	1,170,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,937,398.60	120,986,548.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,240,082.00</b>	<b>25,094,951.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,175,995.00</b>	<b>20,799,770.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	686,057.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,073,200.00	15,948,570.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,276,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,896,338.00	3,211,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	244,000.00	1,639,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>4,280,110.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,280,110.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>64,087.00</b>	<b>15,071.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,087.00	15,071.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>8,761,534.20</b>	<b>-94,738,308.23</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>58,699,461.45</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	58,699,461.45	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-58,699,461.45</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-49,937,927.25</b>	<b>-94,738,308.23</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>693,343,943.00</b>	<b>765,424,596.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>2,028,696.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	2,028,696.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,028,696.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,028,696.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,343,943.00</b>	<b>763,395,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	681,568,600.00	635,284,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	681,568,600.00	635,284,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,089,286.00	16,914,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,089,286.00	16,914,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	111,197,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	111,197,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	686,057.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	686,057.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>693,343,943.00</b>	<b>746,197,146.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>693,343,943.00</b>	<b>746,197,146.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>622,713,871.00</b>	<b>716,378,815.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	393,442,535.00	479,415,046.00
210101	Үндсэн цалин	333,824,874.00	358,450,646.00
210102	Нэмэгдэл	46,853,900.00	78,249,200.00
210104	Урамшуулал	12,763,761.00	42,715,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,605,862.00	66,742,300.00
210201	Тэтгэврийн даатгал	32,865,545.00	46,960,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,694,733.00	4,945,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,924,300.00	3,956,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	742,297.00	989,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,378,987.00	9,890,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	128,036,911.00	103,919,390.00
210301	Гэрэл, цахилгаан	5,738,000.00	5,723,085.00
210302	Түлш, халаалт	122,170,527.00	98,196,305.00

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	128,384.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,766,157.00</b>	<b>6,999,594.00</b>
210401	Бичиг хэрэг	636,240.00	1,761,450.00
210402	Тээвэр, шатахуун	1,073,470.00	1,281,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	277,947.00	365,844.00
210404	Ном, хэвлэл	501,300.00	1,945,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,277,200.00	1,465,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,652,120.00</b>	<b>28,951,206.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	186,300.00	470,066.00
210502	Хоол, хүнс	29,870,590.00	27,347,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	595,230.00	1,133,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,671,700.00</b>	<b>4,669,400.00</b>
210602	Тавилга	00.00	1,671,000.00
210604	Урсгал засвар	1,671,700.00	2,998,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>298,300.00</b>	<b>1,406,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	298,300.00	1,406,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,289,586.00</b>	<b>10,219,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,289,586.00	9,819,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,950,700.00</b>	<b>14,055,979.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,218,900.00	9,872,459.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,731,800.00	4,183,520.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>70,630,072.00</b>	<b>29,818,331.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>70,565,985.00</b>	<b>25,523,150.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	686,057.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,507,190.00	21,103,950.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,276,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,896,338.00	3,211,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	1,207,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>4,280,110.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,280,110.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>64,087.00</b>	<b>15,071.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,087.00	15,071.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>19,227,450.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>19,227,450.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>19,227,450.00</b>

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	19,227,450.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	19,227,450.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-19,227,450.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

#### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний өнөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувьролцооний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	625,099,124.69	1,707,688,860.96
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	625,099,124.69	1,707,688,860.96
D03	Дахин үнэлэхийг эс үзвэл үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	625,099,124.69	1,707,688,860.96
D0	Тайлант үеийн үр дүн			-94,738,308.23	-94,738,308.23
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	364,824,419.85	717,765,316.42	530,360,816.46	530,360,816.46

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	544,895,300.00	540,810,456.04	746,481,900.00	742,186,719.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	544,895,300.00	540,810,456.04	746,481,900.00	742,186,719.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	513,327,600.00	508,818,789.54	724,170,300.00	719,875,269.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,193,900.00	367,544,921.00	477,390,400.00	477,390,400.00
210101	Үндсэн цалин	269,714,900.00	323,323,509.00	356,426,000.00	356,426,000.00
210102	Нэмэгдэл	70,051,600.00	40,615,649.00	78,249,200.00	78,249,200.00
210104	Урамшуулал	30,058,500.00	3,605,763.00	42,715,200.00	42,715,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	368,900.00	00.00	00.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,721,400.00	41,255,635.55	66,742,300.00	66,742,300.00

**Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210201	Тэтгэврийн даатгал	40,721,400.00	41,255,635.55	46,960,900.00	46,960,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	4,945,200.00	4,945,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	3,956,300.00	3,956,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	989,100.00	989,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	9,890,800.00	9,890,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	69,428,400.00	66,241,964.00	104,697,900.00	103,919,390.00
210301	Гэрэл, цахилгаан	3,201,000.00	4,158,809.00	5,738,000.00	5,723,085.00
210302	Түлш, халаалт	65,662,000.00	61,961,655.00	98,755,900.00	98,196,305.00
210303	Цэвэр, бохир ус	565,400.00	121,500.00	204,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,758,500.00	4,390,949.00	8,076,000.00	8,075,694.00
210401	Бичиг хэрэг	487,700.00	1,083,875.00	1,757,400.00	1,757,400.00
210402	Тээвэр, шатахуун	731,600.00	2,633,918.00	1,281,000.00	1,281,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,021,800.00	33,871.00	366,000.00	365,844.00
210404	Ном, хэвлэл	643,700.00	266,400.00	3,026,000.00	3,025,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	873,700.00	372,885.00	1,465,600.00	1,465,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,512,800.00	23,879,140.00	28,964,600.00	28,951,206.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,400.00	112,600.00	483,300.00	470,066.00
210502	Хоол, хүнс	22,566,600.00	22,560,600.00	27,347,800.00	27,347,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	798,800.00	1,205,940.00	1,133,500.00	1,133,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	955,800.00	849,200.00	20,250,000.00	16,748,400.00
210602	Тавилга	00.00	00.00	13,750,000.00	13,750,000.00
210604	Урсгал засвар	955,800.00	849,200.00	6,500,000.00	2,998,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	492,200.00	390,300.00	1,406,800.00	1,406,000.00
210702	Дотоод албан томилолт	492,200.00	390,300.00	1,406,800.00	1,406,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	461,100.00	353,699.99	808,600.00	808,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	461,100.00	353,699.99	408,600.00	408,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,803,500.00	3,912,980.00	15,833,700.00	15,833,479.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,803,500.00	3,912,980.00	11,154,000.00	11,153,959.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	4,679,700.00	4,679,520.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	31,567,700.00	31,991,666.50	223,116,000.00	223,114,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,567,700.00	31,991,666.50	22,311,600.00	22,311,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,008,300.00	15,622,090.50	21,104,000.00	21,103,950.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,559,400.00	16,369,576.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	1,207,600.00	1,207,500.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	544,895,300.00	540,456,756.04	746,481,900.00	742,186,719.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	544,895,300.00	540,103,056.04	635,284,000.00	635,268,929.00
131007	Тусгай зориулалтын	00.00	00.00	00.00	00.00
				635,284,000.00	635,268,929.00

**Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	шилжүүлгээс санхүүжих				
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	111,197,900.00	106,917,790.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	111,197,900.00	106,917,790.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	300,000.00	353,700.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	353,700.00	00.00	00.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	45	45	45	45
620001	Удирдах ажилтан	3	3	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	28	28	28	28
620003	Үйлчлэх ажилтан	14	14	14	14

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөхон	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхнийүлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,089,286.00</b>	<b>16,914,00.00</b>
<b>21</b>	УРСГАЛ ЗАРДАЛ	11,089,286.00	16,914,00.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,089,286.00</b>	<b>16,914,00.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,089,286.00</b>	<b>16,914,00.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэ ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,089,286.00	16,914,00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,089,286.00	16,914,00.00
<b>1311</b>	<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,089,286.00</b>	<b>16,914,00.00</b>
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН:АУДИТОР

Д.ЭНХТУЯА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

